

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2023 он)

1. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/01 ИНЕГ-т. /Safety recommendation 202312/01 МСAA/.

Шувуу агаарын хөлөгтэй мөргөлдсөн тухай бүх мэдээллийг нэгдсэн журмаар ИНЕГ-т бүртгэх, хуулбарыг нь улирал бүр НТОЗШША –нд ирүүлж байх.

2. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/02 ИНЕГ-т, ЧХОУНБ-д, Ханбумбат нисэх буудалд. /Safety recommendation 202312/02 МСAA, Chinggis Khaan International Airport, Khanbumbat Airport/.

Нисэх буудлууд шувууны судалгаа, бүртгэлийг улам бүр сайжруулан зөрчлийн маягыг нэг загварт оруулах түүнийг зөв бөглөх замаар шувуу агаарын хөлөгтэй мөргөлдсөн тайлангийн чанарыг сайжруулах.

3. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/03 ИНЕГ-т, ЧХОУНБ-д, Ханбумбат нисэх буудалд. /Safety recommendation 202312/03 МСAA, Chinggis Khaan International Airport, Khanbumbat Airport/.

Шувуу агаарын хөлөгтэй мөргөлдөх эрсдэлийн судалгааг жил бүр хийж менежментийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан түүний мөрөөр хийсэн ажлыг тайландаа тусгаж байх.

4. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/04 ИНЕГ-т, ЧХОУНБ-д, Ханбумбат нисэх буудалд. /Safety recommendation 202312/04 МСAA, Chinggis Khaan International Airport, Khanbumbat Airport/.

Нисэх буудлын нийт ажилтнуудад шувуу агаарын хөлөгтэй мөргөлдөх эрсдэл, шаардлагатай журам, түүнээс урьдчилан сэргийлэх ач холбогдлын талаар мэдээлэх.

5. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/05 ИНЕГ-т, ЧХОУНБ-д, Ханбумбат нисэх буудалд. /Safety recommendation 202312/05 МСAA, Chinggis Khaan International Airport, Khanbumbat Airport/.

Шувуу агаарын хөлөгтэй мөргөлдсөн зөрчлийн талаар нисэх буудлын шувууны хяналт, судалгааны ажлыг агаарын тээвэрлэгчидтэй уялдуулах замаар бүртгэл, судалгааны ажлыг сайжруулах, ялангуяа нислэгийн үе шат, нислэгийн өндөр, өдөр шөнө-д болсон тохиолдлыг тодорхойлох.

6. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/06 ИНЕГ-т, ЧХОУНБ-д, Ханбумбат нисэх буудалд /Safety recommendation 202312/06 МСAA, Chinggis Khaan International Airport, Khanbumbat Airport/.

Нисэх буудал түүний орчимд боломжтой бол судалгааны хүрээг аль болох ихэсгэх /13 ба 15 км- ээс их болгох/, ялангуяа шувуу их цуглардаг газарт.

7. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/07 ИНЕГ-т, ЧХОУНБ-д, Ханбумбат нисэх буудалд. /Safety recommendation 202312/07 МСAA, Chinggis Khaan International Airport, Khanbumbat Airport/.

“Аэродром орчимд агаарын хөлгийг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх” MNS 6942-ийн тоо хэмжээг нягтлан шалгаж хоёрдмол утгыг нэг болгох, ялангуяа том шувууны эрсдлийн жинг тодорхой болгох.

8. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/08 ИНЕГ-т, ЧХОУНБ-д, Ханбумбат нисэх буудалд. /Safety recommendation 202312/08 МСAA, Chinggis Khaan International Airport, Khanbumbat Airport/.

Орон нутгийн нисэх буудлууд, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид нь аэродромын хяналтын бүсэд ялангуяа шувуу, мал амьтдын анхаарал татаж байгаа байршил /хог хаягдал, жимс ногоо тарих г.м/-ийг тогтмол хяналтандаа байлгаж ийм нөхцлийг үйсгэхгүй байх талаар орон нутгийн засаг захиргаатай нягт хамтран ажиллах.

9. Аюулгүй ажиллагааны шинэ зөвлөмж 202312/09 ИНЕГ-т, Монголиан Эйрвэйс ХХК болон нисдэг тэрэг ашиглагч нарт. /Safety recommendation 202312/09 МСAA, Mongolian Airways LLC and /

Жин тэнцвэржилтийн тооцоог /Weight and balance, loading chart/ Нислэгийн ашиглалтын зааврын FM дагуу хийж гүйцэтгэдэг болох.

10. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/10. ИНЕГ-т. /Safety recommendation 202312/10 МСAA /.

Зорчигч тээвэрлэхэд зориулагдсан нисдэг тэрэгний нисгэгчийн зүүн талын жолоо удирдлагатай суудалд зорчигч тээвэрлэхгүй байх эсхүл жолоо удирдлагыг салгаж ашиглах зохицуулалтыг боловсруулж хэрэгжүүлэх түүнд хяналт тавих.

11. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/11. ИНЕГ-т, Монголиан Эйрвэйс ХХК болон нисдэг тэрэг ашиглагч нарт. /Safety recommendation 202312/11 МСAA /.

Монгол улсад ашиглагдаж байгаа “СИ” системийн бус нэгжийн хэрэглэлтэй агаарын хөлөгт хэмжигдэхүүн нэгжийг хэрэглэх талаар тусгай журам боловсруулж хэрэгжүүлэх.

12. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/12. ИНЕГ-т, Монголиан Эйрвэйс ХХК болон нисдэг тэрэг ашиглагч нарт:

Ослын үеийн автомат байрлал дамжуулагч ELT Transmitter C-406-N HN, Kannad integra 121 AP-H /ELT/-ийн найдвартай ажиллагааг нислэгийн ашиглалтын зааврын дагуу холбогдох байгууллагатай хамтарч сар тутам шалгаж байх.

13. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202312/13. ИНЕГ-т, Монголиан Эйрвэйс ХХК болон нисдэг тэрэг ашиглагч нарт:

Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын Хавсралт “ Annex 6 Part III”- ийн 4.3.-ийн **4.3.1.1.5** дах зөвлөмжийн дагуу холбогдох нисдэг тэрэгт нислэгийн бичлэгийн төхөөрөмжийг суурилуулж ашиглах.